

# **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 5-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

## **1. БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ СЕМИНАРТ ХАМРАГДСАН БАЙДАЛ**

1.1 Номын санч, бичиг хэргийн ажилтан А.Дэлгэрнасан 2019.5.06-10-ны хооронд Улаанбаатар хотод БМДИ-ээс зохион байгуулсан 1дэхь жилдээ ажиллаж байгаа номын санчдын үндсэн сургалтанд хамрагдсан. Нийгмийн ажилтан Д.Эрдэнэчулуун, бага ангийн багш Н.Бямбадолгор, физикийн багш Г.Оюун-Эрдэнэ нар мөн эхний жилийн үндсэн сургалтад хамрагдсан.

## **2. “УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

2.1 2019 оны 5-р сарын 24-ны өдөр ЕБС-ийн 7-8-р ангийн сурагчдын дунд Монгол ёс заншлын төрөл зүйл болох “Цээрлэх ёс, зочлох ёс, хооллох ёс”-зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

2.2 Англи хэл, Физик, Технологи, Мэдээлэл-Зүй, Хими-Биологи, Математикийн хичээлүүдээр мэргэжлийн багш нар самбар гарган 2-р давхарын коридорт байршуулав.

2.3 “Гадаад дууг хэн сайн дуулах вэ?” –уралдааныг сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа.

2.4 Архивын улсын үзлэгт бэлтгэж багш, ажилчид илүү цагаар ажиллалаа.

2.5 Сургуулийн гэр бүлийн зөвлөлөөс санаачлан багш, ажилчдын гэр бүлийн дунд гар бөмбөг, кароакены тэмцээн амжилттай зохион байгууллаа.

2.6 Анги дэвших шалгалтын блюпринтийн дагуу 3-р ангийн 1, 4-р ангийн 7 жишиг даалгавар боловсруулан аймгийн БСУГ-т хүргүүлэв. Мөн аймгийн бусад сургуулиудын даалгавруудаас бүрдсэн нэгдмэл даалгаврын сангаас даалгавар татан түүнийхээ дагуу давтлагын хуваарь гарган хичээллэв. Бага боловсролын анги дэвших шалгалтыг 3-р ангиас “Нэгдмэл агуулга”, 4-р ангиас “Математик, монголхэлтэй нэгдмэл агуулга” болон “Байгалийн ухаан”-ны хичээлүүдээр, 5-р ангийн төгсөх шалгалтыг “Математик”, “Монгол хэл”, “Байгалийн ухаан”-ны хичээлүүдээр аймгийн БСУГ-ын болон БҮТ-ийн даалгаврын сангаас тус тус материалыг боловсруулан авлаа. Шалгалтын гүйцэтгэл: 3-р анги- 62%, 4-р ангийн БУ -77,3%, 4-р ангийн нэгдмэл-62,1%

2.7 5-р ангийн Монгол хэл- 63%, Математик – 38%-тай шалгагдсан байна. 5-р ангийн БУ-ны шалгалт авагдаагүй байна.

2.8 2018-2019 оны хичээлийн жилийн 1-р ангийн сурагчдын “Эрдмийн баяр” болон тайлант уншлагыг эцэг эхтэй хамтран амжилттай зохион байгууллаа. Сурагчдын тайлант уншлагын гүйцэтгэл -79,5%-тай хангалттай түвшинд

үнэлэгдэв. Нийт 17 сурагч хамрагдахаас 100% бүрэн хамрагдсан ба 90-с дээш хувьтай буюу VIII түвшинд 5 сурагч шалгагдлаа.

2.9 Анги дэвших болон төгсөх шалгалтын бэлтгэлийг чанаржуулах зорилгоор “Хэний анги хамгийн сайн бодлого бодох вэ?” сарын аяныг 4 сарын 15- 5 сарын 15-ны хооронд зохион байгууллаа. Тус уралдааныг долоо долоо хоногоор 4 үе шаттай зохион байгуулж 7 ноног бүр шалгалт авч үнэлэн дахин ахицыг тооцон ажилласан нь үр дүн сайтай сурагчдын мэдлэг чадвар ахисан ажил боллоо. Үүний үр дүнд аймгийн математик цаг сонины 2-ын двааны олимпиадад бага ангийн 8 сурагч шагналт байранд орлоо. Үүнд 3-р ангийн 2 сурагч 3-р байр хүрэл медаль, 5-р ангийн-2, 3-р ангийн- 3, 2-р ангийн – 1 сурагч тус бүр тусгай байранд орлоо

### **3. СУРГАЛТЫН ОРЧИН САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

3.1.9, 12-р ангийн сурагчид ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургуулийн хаушаа болон П.Гэндэн сайдын цогцолборт нийт 40 мод суулгалаа.

3.2 Аяны хүрээнд анги бүр ангидаа цэцгийн тоо болон нэр төрлийг олшруулах талаар ажил зохион сурагчдаар өөрсдөөр нь гардан цэцэг тариулав. Мөн 5-р ангийн эцэг эхчүүд Ногоон орчин бүтээн байгуулалтын жилд зориулан сургуулийн захиргаанд цэцгийн сав авах 50000 төгрөг хандивлав.

3.3 Төгсөх 5-р ангийн сурагчдаар сургуулийн урд талбайд цэцгийн мандал тариулах зорилгоор хуучин дугуй цуглуулан мандлын суурь бэлтгэх ажил хийгдэж байна 6 сарын эхний 7 хоногт тарьж дуусгахаар төлөвлөөд байна.

### **4. ХҮҮХДИЙН АВЪЯАС, СУРЛАГА ХҮМҮҮЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

4.1 Сурагчдын авьяас ур чадварыг нээж хөгжүүлэх ажлын хүрээнд хангайн бүсийн ЕБС-ийн дотуур байрын сурагчдын дунд” Нэг ертөнц” урлаг спортын өдөрлөгийг 5-р сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгууллаа

Энэ удаагийн өдөрлөгөөр 3-сургуулийн 45 сурагчид нийгмийн ажилтан байрын багш ажилчид оролцож, шатар гар бөмбөг болон урлагийн 6-төрлөөр авьяас ур чадвар авхаалж самбаагаараа өрсөлдөн Хайрхандулаан сумын “ Ханхөгшин “баг түрүүлж , Жаргалант сумын “Жавхаа” баг удаалж,Тарагт сумын “Шонхор” багууд тус бүр шалгарлаа.

4.2 Аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулсан”Өсвөрийн цагдаа-2019” тэмцээнд 7 сургуулийн 70 сурагчид өөрсдийн авьяас чадвар мэдлэг оюунаараа өрсөлдөж хүүхэд хүүхдээсээ суралцдаг уг үйл ажиллагаанд тус сургуулийн “Өсвөрийн цагдаа” клубын 10 сурагчид 5-төрлөөр амжилттай оролцлоо

4.2 1-5-р ангийн сурагчдын дунд “Нэг хүүхэд-нэг витамин” сайн үйлсийн аяныг зохион байгууллаа. Анги бүр эмчийн зөвөлгөөгөөр хүүхэд болон өндөр настай 1 хүнд дархлаа сайжруулах зорилгоор витамин авч өгөв. Үүнд

1-р анги 18000 төгрөгний үнэ бүхий витагриф болон вакус Өндөр настан Мөнхнасанд,

2-р анги анги 18000 төгрөгний үнэ бүхий витамин \витагриф болон вакус\ өндөр настан Пүрэвд,

3-р анги 20000 төгрөгний үнэ бүхий витамин \коркума, витагриф \ Төртүвшингийн 1 настай хүүхдэд

4-р анги 20000 төгрөгний үнэ бүхий витамин \коркума, витагриф \ П.Мөнгөнхүүгийн 1 настай хүүхдэд

5-р анги 8500 төгрөгний үнэ бүхий витамин \витамин-С-17 ш\ СӨББ –ийн бага бүлгийн 17 хүүхдэд тус тус өгч биений дархлааг нь дэмжин сайн үйлс хийлээ.

**4.10 Номын сан:** Үлгэр зохиомжоор сэдэвлэн бяцхан номын уралдаан зохиолоо.

**4.11** 1-2-р ангийн сурах бичгийг хураан авч техник ажиллагаа хийлээ.

**4.12** Номын сангийн үйлчилгээнд цаасан каталоги нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.

**4.13** Бага ангийн 4-р ангийн сурагчдын дунд “Уран жиргээ” уран уншлагын тэмцээнийг багш Н.Бямбадолгортой хамтран 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Үүнд 4-р ангийн 17 сурагч 5-р ангийн 8 сурагч оролцов. 1-р шатанд 8 сурагч шалгарч 2-р шатанд “Багш” сэдвээр шүлэг зохиолгон шалгарууллаа. 1-р байранд 4-р ангийн сурагч Б.Ариунсанаа, 2-р байранд 4-р ангийн сурагч Б.Давааням, 3-р байранд 5-р ангийн сурагч У.Насанчимэг нар шалгарлаа.

## **5 ОЛИМПИАД, УРАЛДААН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН БАЙДАЛ**

**6.1** “Гадаад хэл хөгжлийн түлхүүр” аяны хүрээнд Массын олимпиадын 3-н даваанд 8а анги орос хэлний хичээлээр аймагт 2-р байранд орж, 3-н даваанд бэлтгэн оролцууллаа.

**6.2** Тээгч түгээгч олимпиадад 6-12-р ангиудаа бэлтгэн амжилтай оролцууллаа.

**6.3** “Эх хэл эрдмийн түлхүүр” аяны хүрээнд массын олимпиадад 2-н даваанд аймагт 6-р байранд орж, 3-н даваанд бэлтгэн оролцууллаа.

## **6 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ**

**6.1 1.** Багш сурагчдын эрүүл мэндэд хяналт тавин, эрүүл мэндийн тусламж үзүүлэх шаардлагатай багш, ажилчид, сурагчидад анхны тусламж эмийн болон эмийн бус эмчилгээ хийж ажиллаж байна.

2. Дотуур байрны сурагчдын хоолны орц норм, илчлэг чанар, хадгалалт зэрэгт хяналт тавин 14 хоногт 1 удаа амталгаа хийж заавар зөвөлгөө өгч 2 тогоочтойгоо хамтран ажиллаж байна.
3. 1-5-р ангийн сурагчдын үдийн цайнд хяналт тавин, сурагчдын гарын ариун цэвэр, хоолны аяга, цайны аяга, халбага, сэрээ, алчуур шалгаж сурагчидад болон анги удирдсан багш нарт заавар зөвлөгөө үүрэг даалгавар өгч ажиллаж байна.
4. “Улаан бурхан өвчинд цэг тавья” дархлаажуултанд 10-18 насны 4-12-р ангийн 141 сурагчдыг хамруулсан.
5. Арвай хээрт 5.14нд “Улаан бурхан өвчны талаархи” сургалт 5.10нд “Залуу эмч нар”-ын чуулга уулзалтанд оролцсон.
6. Сургуулийн захирал Ц.Хоролмаа “Ёс зүй харилцаа хандлага” НТББ Норовсүрэн “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалтанд хамрагдсан.
7. 5.15нд “УЛААН БУРХАН” өвчинд цэг тавья дархлаажуулалтын 10 хонгийн нээлт хийсэн.
8. Сургууль, дотуур байрны цэвэрлэгээнд хяналт тавин заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.
9. Дотуур байрын сурагчдын эрүүл ахуйд хяналт тавин, 7 хоногт 2 удаа дотуур байрын сурагчдын ариун цэвэр шалгаж заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.
10. “Нэг ертөнц” хангайн бүсийн дотуур байрын сурагчдын дундах “ГАР БӨМБӨГ”-ийн тэмцээнийг Б.Алтанхуяг багштай хамтран зохион байгуулсан.
11. Сургуулийн хашааг Н.Адъяадорж, жижүүр Б.Энхбаатартай хамтарч засаж янзалсан. Сургуулийн хашаан доторх шороог үйлчлэгч Д.Жандаг, С.Энхсүрэн, Д.Жоншмаа нартай хамтарч цэвэрлэж цэвэр орчин бүрдүүлсэн.
12. Дотуур байрын гадна талбайн цасыг цэвэрлэсэн.
13. Дотуур байранд хувцасны шкаф угсарч, цэцгийн тавиур хийж эко орчин бүрдүүлсэн.
14. Дуу хөгжим багш Б.Буяндэлгэртэй хамтран өдөр бүр сурагчидад дасгал хийлгэж хэвшүүлж байна.

## Бүтээлч ажлын хүрээнд:

- Сургамжит өгүүллэг-ийн “Бэрхшээл” өгүүллэгээр 10а ангийн сурагчидтай хэлэлцүүлэг хийж хүн алтваа бэрхшээлийг даван гарахад хэцүү гэхээсээ надад ямар боломж, чадвар байгаагаа харах хэрэгтэй юм байна гэж дүгнэн ярилцлаа

- Төгсөх ангийн сурагчдын “Эрдмийн баярын” үйл ажиллагааг 5-р сарын 17-нд Соёлын төвд эцэг эхийн хамт ёслон тэмдэглэлээ Энэ өдөр 5,9,12-р ангийн сурагчид эрдэм мэдлэгийн уурхай болсон ачит багш нартаа баярлаж талархаж байгаагаа илэрхийлж ая дууны мэндчилгээ дэвшүүлээ Эрдмийн баяраа тэмдэглэж байгаа сурагчиддаа шэгнэлын хур буулгаж ЭЕШ-нд амжилт хүсч ажил амьдралын замд хөл тавих гэж буй хүүхдүүдээ ахмад багш Ө Сүхбаатар багш үнэтэй сургааль сургамжаа хайрлалаа Мөн энэ өдөр хүүхдийнхээ сурлага хүмүүжилд анхааран сургууль-багш –эцэг эх гэсэн эргэх холбоотой ажилладаг эцэг эхчүүдийг шалгаруулан Д Чимэдгочоо Н Баярдолжин Б Баярмагнай нарыг “Тэргүүний эцэг эхээр” өргөмжлөн шалгарууллаа Улаанбаатар хотод БМДИ-д нийгмийн ажилтаны сургалтанд 5-р сарын 20-24-ны өдөр хамрагдсан

- Аймгийнзасагдарга Г Ганболд, БСУГ-ындарга Ж Пүрэвсүрэнболонхэлтэсалбадын даргана рирж сургууль, дотуурбайрны орчин нөхцөл үйлэж иллагаатай танилцлаа.

Энэ удаагийн нуулзалтаар сурагчдын сурч хөгжих орчныг нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн дээд эргэж засварлах спортзал шинээр барьж дэмжлэг үзүүлэхээр боллоо.

Энэ үеэр төгсөх ангийн сургчидтай уулзаж ажлын байрны эрэлт хэрэгцээ мэргэжил эхэрхэн оновчтой сонгож байгаатаа харилцан ярилцлаа.

Мөн багш ажилчид ардир гэдтэй уулзаж санал бодлоо солилцсон

- Багш ажилчид сургууль дотуур байрын орчинд их цэвэрлэгээ хийж гадна хашааны битүүмжлэлийг бүрэн бүтэн болгон засварлан сайжруулах ажлыг хийсэн Тохжилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сургууль дотуур байранд эко орчин бүрдүүлэн 13- тасалгааны цэцэг, гадна талбайд 10 дугуйнд цэцгийн үр суулгаж, төгсөх ангийн сурагчид эцэг эхчүүд 60 мод/шар хуайс/ тарьж, ЭКО- клубын чиглүүлэгч багш С Оюунэрдэнэ сурагчидтай хамтарч гадна орчинд зүлэгжүүлэх ажлыг хийсэн. Энэ орчныг хамгаалах, хайс хашаа хийж арчилж тордох ажлыг ажилчид хамтран хийлээ .

- Тус сумын соёлын төвийн нээлтэнд 5 багш 250-хүний хүлээн авалтын үйлчилгээнд оролцлоо Багш нарын заах аргын нэгдэл тус бүр сурагчдад зориулсан судлагдхууны болон бүтээлийн самбар 4-ийг шинээр нэмж хийсэн

## СУРГУУЛИЙН ЗАХИРГАА